

ХОЁР. БАГШИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ УР ЧАДВАРЫГ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРГЭХ

НЭМС-ийн Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд эрдмийн зэрэг, цолтой багш нарын тоог нэмэгдүүлэх, дотоод, гадаадын сургалтанд тасралтгүй хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, нийт багш нарын мэргэжлийн зөвлөл болон мэргэжлийн салбарт зөвлөлд ажиллах тоог нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

2.1. Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувийг нэмэгдүүлэх

АШУҮИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөрийн шилдэг хүний нөөцийг бүрдүүлж, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, судалгааны ур чадварыг олон улсын түвшинд хүргэх зорилтын хүрээнд НЭМС-ийн докторын эзлэх хувийг нэмэгдүүлэх ажлыг багшийн хөгжлийн дэд хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байна. НЭМС-ийн нийт багш нарын 47% нь доктор ба түүнээс дээш зэрэгтэй. Сүүлийн таван жилд эрдмийн зэрэг ахиулсан багшийн тоо 5-аар нэмэгдсэн. Үүнээс гадаад улсад 2 багш, дотоодод 3 багш докторын зэргээ хамгаалсан. 2020 онд Израйль улсад 1 багш НЭМ-ийн чиглэлээр магистр хамгаалсан. Нийт 14 багш докторантурт суралцаж байгаагаас 4 багш гадаадын их сургуульд, 10 багш дотооддоо суралцаж байна. Гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлсний дүнд 1 багшийг Сөүлийн ИС-д докторантурт сургах, 2 багшийг Финлянд улсад урилгаар багшлуулахаар болсон.

Сүүлийн 5 жил докторын зэрэг хамгаалсан багш нар:

1. Эрүүл мэндийн бодлогын тэнхимийн багш Л.Хоролсүрэн 2018 онд Солонгос улсад Төрийн бодлогын ухааны доктор;
2. ШТСТ-ийн багш М.Мөнхзаяа 2020 онд АУ-ны докторын зэргийг “Улаанбатаар хотын сургуулийн насны хүүхдийн бие бялдрын өсөлт, хөгжлийн судалгаа” сэдвээр;
3. ЭБТ-ийн багш О.Гэрэлмаа 2020 онд “Хотын хүн амын сүрьеэгийн өвчлөл, эрсдэл, хавьтлын судалгаа” сэдвээр;
4. ЭБТ-ийн тэнхимийн багш Ш.Оюу-Эрдэнэ 2021 онд Монгол улсын өсвөр насныхан, залуучууын гепатитын В, С вирусын халдварын тархалт, дархлал тогтоц, эрт илрүүлгийг судлах асуудалд сэдвээр;
5. Эрүүл мэндийн бодлогын тэнхимийн багш Т.Ариунтуяа 2021 онд Голландын “Гронингенийн Их Сургууль” доктор;
6. УСАУ-ийн тэнхимийн багш Ч.Өнөрцэцэг 2020 онд Израйль улс Олон улсын НЭМ-ийн магистрын зэргээ тус тус амжилттай хамгаалсан.

2.2. Гадаадад доктор, магистрийн зэргээр суралцуулах багшийн тоог нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх, сургуулиудад хүсэлт илгээх

Өмнөх туршлага дээр үндэслэн, цаашдын гарц шийдлийг олох, бусад гадаад их дээд сургуультай хамтран ажиллах, багшийг суралцуулах, мэргэжил дээшүүлэх чиглэлээр анхаарч ажиллаж байна. Орчны эрүүл мэндийн тэнхимийн багш Э.Ундармаа Канад улсын “Саймон Фрейзерийн Их сургууль”-д докторантурт сурацаж байна.

- 1.1. Эпидемиологи, биостатистикийн тэнхимийн багш Ц.Энх-Оюун Канад улсад пост-докторын сургалтанд хамрагдаж байна.

- 1.2. ЭБТ-ийн тэнхимийн ахлах багш Д.Гантуяа докторын дараах сургалтад, ШТС-ын тэнхимийн багш М.Мөнхзаяа докторын судалгааны тэтгэлгээр Канад улсын Квинсийн их сургуульд суралцсан.
- 1.3. Орчны эрүүл мэндийн тэнхимийн багш Ү.Эрдэнэзул Японы Жичигийн их сургуулийн НЭМ-ийн сургуулийн докторантурын тэтгэлэгт хөтөлбөрт хүсэлт гарган эхний 2 шалгаруулалтанд тэнцсэн.
- 1.4. Орчны эрүүл мэндийн тэнхимийн багш Ц. Оюуг докторантурт сурахаар Сөүлийн Үндэсний Их Сургуулийн НЭМС-д хүсэлтээ өгч, баталгаажсан.
- 1.5. 2019 оноос ЭБТ-ийн багш Б.Нямсүрэн БНСУ-Сөүлийн Үндэсний Их Сургуульд докторын хөтөлбөрт суралцаж байна.
- 1.6. 2022 онд докторын судалгааны ажлаа ахиулах зорилгоор докторант багш Н.Туул, Л.Хулан нар Герман улсын Лайпцик болон Иена хотын Макс планкын их сургуулийн археогенетийкийн лабораторид очиж ажилласан.
- 1.7. ШТС-ийн багш Ү.Эрдэнэзул Унгар улсад докторын сургалтанд хамрагдаж байна. 2022

Багш нарын докторын судалгааны ажлыг ахиулах:

НЭМС дээр хэрэгжиж байгаа гадаадын их, дээд сургууль, олон улсын байгууллагын болон дотоодын байгууллагын санхүүжилттэй хэрэгжүүлж байгаа төслүүдэд эрдмийн зэрэгтэй багш нар 100 хувь оролцож, АШУҮИС докторант, магистрант нарт судалгааны ажлын сэдэв өгч хамгаалах боломжийг бүрдүүлж байна. Докторын сургалтанд хамрагдсан багш нарыг сургууль дээр хэрэгжиж байгаа төсөлт ажилд татан оролцуулж, судалгааны ур чадварт сургаж, улмаар докторын зэрэг хамгаалах судалгааны сэдэв, чиглэлийг тодорхойлдог. Хугацаа хэтэрсэн, хамгаалалтын явц удааширч байгаа докторант багш нарын судалгааны ажлын явцыг хурдасгах зорилгоор төлөвлөгөө гарган ажиллуулж байна. Үүнд:

1. ШТСТ-ийн докторант багш Н.Туул судалгааны арга, аргачлалаа НЭМ-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар батлуулсан. 2022
2. ШТСТ-ийн докторант багш Л.Хулан судалгааны арга, аргачлалаа НЭМ-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар батлуулсан. 2022
3. УСАУТ-ийн докторант багш Ж.Маргад-Эрдэнэ судалгааны арга, аргачлалаа НЭМ-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар батлуулсан. 2022
4. ЭМНАНУТ багш О.Саранчулуун докторын ажлын явцыг хэлэлцүүлгийг НЭМ-ийн ЭЗ-өөр хэлэлцүүлж, судалгааны ёс зүйн хороогоор хэлэлцүүлж, дүгнэлт авсан. 2022
5. Докторын явцын хэлэлцүүлэгт ОЭМТ-ийн багш Г.Жаргалсайхан, ЭМНАНУТ-ын багш Д.Мөнх-Учрал нар орсон, 2022
6. ЭБТэнхимийн багш Х.Сэр-Од арга аргачлалаа батлуулсан, 2022
7. ОЭМТ-ийн багш М.Нансалмаа докторын арга аргачлалаа батлуулсан, 2023

Докторантын сургалтын тэтгэлэг олгох:

2020 онд Канадын Саймон Фзейзер их сургуультай хамтран хэрэгжүүлж буй УГААР-2 төслийн дэмжлэгтэйгээр Залуу багш нарыг Олон улсын хуралд оролцож илтгэл хэлэлцүүлэхэд нь дэмжлэг үзүүлж *Travel Grant*-олгосон /4,5 сая₮/. УГААР төслийн хүрээнд 2021 болон 2022 онд докторантурт суралцаж байгаа 2 оюутанд 5 сая төгрөгний тэтгэлэг олгосон. Тамхинаас гаргах зан үйлийн интервенц төслийн хүрээнд 1 докторант багш,

Германы “Dairy cultures” төслийн хүрээнд 2 докторант багшийн судалгааны ажлыг санхүүжүүлж байна.

2.3. Төслийн аргачлал боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр багш нарыг сургалтад хамруулах

Нийт багш нарын 10% нь 2012 оноос хойш төсөл бичих, боловсруулах албан ёсны сургалтад хамрагдсан байгаа бөгөөд цаашид сургалтад хамрагдсан багшийн тоог нэмэгдүүлэхээр зорь ажиллаж байна. 2018 оноос хойш багш нар шинээр 18 төслийн санал бичиж хүргүүлсэнээс 8 төсөл хэрэгжсэн байна.